

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Г Арилжааны програмд өөрчлөлт г
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 15.1, 34.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжаагаар өмчлөгч нь өөрчлөгдөөгүй хэлцэл хийхийг хязгаарлах үүднээс арилжааны програм хангамжид зохих өөрчлөлт оруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч биелэлтийг 2010 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороонд тайлагнахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН